

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН  
ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ  
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 6 дугаар  
сарын 29-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд өө,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн.

Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатараар ахлуулан, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж, Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан нарын бүрэлдэхүүнтэйгээр хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах дэд ажлын хэсэгт холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан.

Байнгын хороо 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед өргөдөл нь захиргааны байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар гаргасан саналын шинжтэй, эсхүл хуульд заасан өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх талаар гаргасан хүсэлтийн шинжтэй байх, өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэлтэд хяналт тавих, шийдвэрлэлтийн талаар тайлан, мэдээ гаргах, нийтэд тайлагнах журмыг Засгийн газар батлах зэрэг зарчмын зөрүүтэй 8 санал болон найруулгын шинжтэй 4 саналыг ажлын хэсгээс гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн ажлын хэсгээс Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгтэй зөрчилдөж байна гэж үзсэн тул хуулийн төслийг хууль санаачилагчид нь буцаах санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд өө,

Захиргааны өрөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зэрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**С.БЯМБАЦОГТ**

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн санал:**

**1. Төслийн 1 дүгээр зүйлийн "дараах" гэсний дараа "бүлэг," гэж нэмж, мөн зүйлийн 1 дэх заалтыг хасах.**

**Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар,  
Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Б.Пүрэвдорж,  
Ш.Раднаасэд, Б.Энх-Амгалан  
/цаашид "Ажлын хэсэг" гэх/**

**2. Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 93.4 дэх хэсгийн "хүргүүлэх" гэсний дараа ", нийтэд тайлагнах" гэж нэмэх.**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**3. Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 93<sup>1</sup>.2, 93<sup>1</sup>.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 93<sup>1</sup>.2 дахь хэсэг болгох:**

**"93<sup>1</sup>.2. Энэ хуулийн 92.4-т заасны дагуу гаргасан гомдлыг холбогдох албан тушаалтан тэмдэглэн авч, бүртгэлд бүртгэнэ."**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**4. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 93<sup>2</sup>.1.1 дэх заалтыг хасах.**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**5. Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 99<sup>1</sup>.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:**

**"99<sup>1</sup>.3. Өргөдөл нь гомдлоос бусад захиргааны байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар гаргасан саналын шинжтэй, эсхүл хуульд заасан өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх талаар гаргасан хүсэлтийн шинжтэй байна."**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**6. Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 99<sup>3</sup>.1 дэх хэсгийн "захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулах, шинэчлэх талаар" гэснийг "захиргааны байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар гаргасан" гэж, 99<sup>5</sup>.1 дэх хэсгийн "буюу эрх бүхий бусад" гэснийг "эрх бүхий" гэж тус тус өөрчлөх.**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**7. Төслийн 1 дүгээр зүйлийн 11 дэх заалтын 99<sup>2</sup>.1.5 дахь заалт, 99<sup>3</sup>.3, 99<sup>4</sup>.3 дахь хэсгийг тус тус хасах.**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

**8. Төслийн 3 дугаар зүйлийн "зүйл," гэснийг хасах.**

**Санал гаргасан: Ажлын хэсэг**

## НАЙРУУЛГЫН САНАЛ

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтын 60.5 дахь хэсгийн "уг" гэснийг "тухайн" гэж, 7 дахь заалтын 92.4 дэх хэсгийн "цахим сүлжээгээр дамжуулан" гэснийг "хандан" гэж, 92.5 дахь хэсгийн "дугаараа бичиж, гарын үсэг зурах буюу" гэснийг "дугаар бичиж, гарын үсэг зурж" гэж, мөн зүйлийн 8 дахь заалтын 93.3 дахь хэсгийн "Гомдол" гэснийг "Гомдлыг" гэж, 93.4 дэх хэсгийн "хүлээн авч" гэснийг "хүлээн авах" гэж, мөн зүйлийн 10 дахь заалтын 93<sup>2</sup>.1 дэх хэсгийн "ундэслэл байвал" гэснийг "ундэслэлээр" гэж, 11 дэх заалтын 99<sup>1</sup>.2 дахь хэсгийн "тус улсын нутаг дэвсгэрт байгаа" гэснийг "Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа" гэж, 99<sup>2</sup>.1.1 дэх заалтын "гаргасан өргөдлийнхөө" гэснийг "өргөдлийн" гэж, 99<sup>2</sup>.1.2 дахь заалтын "гаргасан өргөдөлтэй" гэснийг "өргөдөлтэй" гэж, 99<sup>2</sup>.1.3 дахь заалтын "татгалзаж буцаан авах" гэснийг "татгалзах" гэж, 99<sup>2</sup>.1.4 дэх заалтын "өгсөн" гэснийг "өргөдлийн" гэж, 99<sup>3</sup>.3 дахь хэсгийн дугаарыг "99<sup>3</sup>.5" гэж тус тус өөрчлөх.

**Санал гаргасан:Ажлын хэсэг**

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын тайлбарын "зөвхөн" гэснийг, 9 дэх заалтын 93<sup>1</sup>.4 дэх хэсгийн "өөрт нь" гэснийг, 8 дахь заалтын 93.3.2 дахь заалтын "заавал" гэснийг, 10 дахь заалтын 93<sup>2</sup>.2 дахь хэсгийн "гомдлын" гэснийг, 11 дэх заалтын 99<sup>3</sup>.1 дэх хэсгийн "цахим сүлжээгээр дамжуулан" гэснийг тус тус хасах.

**Санал гаргасан:Ажлын хэсэг**

3. Төслийн 1 дүгээр зүйлийн 10 дахь заалтын 93<sup>2</sup> дугаар зүйлийн "байх" гэсний дараа "ундэслэл" гэж, 11 дэх заалтын 99<sup>3</sup>.2 дахь хэсгийн "хуулийн этгээд" гэсний дараа "олон нийтийн" гэж тус тус нэмэх.

**Санал гаргасан:Ажлын хэсэг**

4. Төслийн 3 дугаар зүйлийн "2/47 дугаар зүйлийн 47.1.6 дахь заалт" гэснийг "3/47 дугаар зүйлийн 47.1.6 дахь заалт" гэж өөрчлөх.

**Санал гаргасан:Ажлын хэсэг**

---оОо---

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ  
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ  
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

1. Төслийг хууль санаачлагчид нь буцаах.

**Санал гаргасан:Ажлын хэсэг**

---оОо---